

“РЕМИКОН” ХК-НЫ 2017 ОНЫ ЭЭЛЖИТ
“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ”-ЫН ПРОТОКОЛ

2017 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Хурал эхэлсэн цаг минут:

11:00 цагт

Ц.Эрдэнэбаяр: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Ремикон” ХК-ийн 2017 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэхэд бэлэн боллоо. Миний бие Ц.Эрдэнэбаяр нь хурлын даргыг томилогдсон болно. Ингээд ХЭХурал нээснийг мэдэгдье. Хурлын ирцийг тооллогын комиссын дарга Б. Алтанцэцэг танилцуулна уу.

Б. Алтанцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би хурлын тооллогын комиссын дарга Б. Алтанцэцэг байна. Та бүхэнд хурлын ирцыг танилцуулъя. Хуралд нийт 13 хувьцаа эзэмшигч ирсэн бөгөөд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо нь нийт хувьцаа эзэмшигчдийн 0.85 % хувийг эзэлж байна. Брокер дилерийн компаниар дамжуулан бичгээр санал авах хуудсыг ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй болно.

Ц.Эрдэнэбаяр: Компанийн тухай хуулийн 69.1-д заасан Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно гэсэн заалтыг хангахгүй байгаа учир Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшлуулахаас өөр аргагүй болж байна. Хойшлогдсон хурлыг хуралдуулах хугацааны талаар ТУЗ-ын нарийн бичгийн дарга мэдээлэл өгнө үү.

Н. Энх-Очир: Сайн байцгаана уу. Компанийн тухай хуулийн 69.1-д заасан Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно гэсэн заалтыг хангахгүй байгаа учир хурлыг хойшлуулах нь зөв.

Харин Компанийн тухай хуулийн 69.6-д зааснаар “хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос

доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.” Мөн “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 3.8-д заасны дагуу “Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл, протокол үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган хурлыг хойшлуулна. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг холбогдох материалын хамт Хороонд ажлын 4 хоногт багтаан ирүүлнэ.” гэж заасан байгаа.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Компанийн тухай хууль болон хорооноос гаргасан журамд заасны дагуу хурлын ирц хүрээгүй тухай тэмдэглэл, протокол үйлдэж, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гаргаж материалыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх ажлыг Хурал зохионы байгуулах комисст үүрэг болгоё.

Харин хойшлогдсон хурлын товыг 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гаригт 11.00 цагт “Хера Индастриал парк”-ийн байранд хуралдахаар тогтоё.

Н. Энх-Очир:

Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн өдрийн хуралдаанаас дараах шийдвэр гарч байна.

1. Компаний тухай хуулинд заасан хурлын ирц хүрээгүй тул Ремикон ХК-ийн 2017 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хойшлуулан хуралдуулах.
2. Хойшлогдсон хурлын товыг 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гаригт 11.00 цагт “Хера Индастриал парк”-ийн байранд хуралдахаар тогтоох.
3. Хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг 2017 оны 5 дугаар сарын 16-ний өдрийн дотор дахин мэдэгдэхийг Ремикон ХК-ийн гүйцэтгэх удирдлагад даалгах.

Ц.Эрдэнэбаяр: Та бүхэнд хурал хаасныг мэдэгдье.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР